

НЭГДСЭН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
НЭРГҮЙН ЗОЛЖАРГАЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ УРТ, ДУНД, ХУГАЦААНЫ БОДЛОГО, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, БОДЛОГО ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ, ҮР ДҮНГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ БОЛОВСРУУЛАХ, ТӨЛӨВЛӨХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”							
1.	Үндэсний болон орон нутгийн түвшний хөдөлмөрийн зах зээлийн болон холбогдох харьцуулсан судалгаанд дүн шинжилгээ хийх, мэдээллийг нэгтгэн боловсруулах.	Сар, улирал, хагас бүтэн жил	2023 оны жилийн эцсийн тайлан	ХЗЗ мэдээг сар бүр өссөн дүнгээр эцэслэн боловсруулсан байна.	Хөдөлмөрийн зах зээлийн 2023 оны тоон мэдээг сар, улирлаар, жилийн эцсийн байдлаар (Үндэсний статистикийн хороо www.1212.mn, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар) зэрэг холбогдох газар хэлтсээс авч нэгтгэн, боловсруулж, харьцуулсан дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангасан. Мөн тус яамны вэб сайтад мэдээллийг нээлттэйгээр байршуулсан. Үүнд: - Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтийн талаарх мэдээлэл (хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин г.м) 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-3 дугаар улирлын тоон мэдээ	2024.01.02-2024.12.31	100%

					- 2016-2023 он, 2024 оны 1-11 дүгээр сарын байдлаарх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний мэдээлэл - 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-11 дүгээр сарын харьяа агентлагийн хөдөлмөрийн зах зээлийн тоон мэдээ /Ажил хайгч, бүртгэлтэй ажилгүй иргэн, ШАБ, ажлын байрны захиалга, АМЧБОУ, Гадаад ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн болон бусад/		
2.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах бодлого, арга хэмжээг төлөвлөх, санал боловсруулах	Арга хэмжээний төсөл-1	2023 оны ЗГҮАХ-ийн жилийн эцсийн тайлан	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах бодлого, арга хэмжээг төлөвлөж санал боловсруулсан байна.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд холбогдох 3 хүснэгтийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагаанд тусгах саналыг нэгтгэн боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яамруу 2024 оны 11 дүгээр сарын 11-ний 01/1198 бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хариуцан хэрэгжүүлэх 57 зорилтын 105 арга хэмжээний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 15 зорилтын 31 арга хэмжээний саналыг тусгасан байна.	2024.10.18-2024.12.31	100%
Зорилт 2. “ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”							
1.	Бодлого, хууль тогтоомж, тогтоол,	Ажлын хэсэг	Гэр бүл, хөдөлмөр	Гэр бүл, хөдөлмөр,	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тогтолцоонд дүн шижилгээ хийх,	2024.09.20-2024.12.31	90%

	шийдвэрийн хэрэгжилт, практикийг судалж, тэдгээрийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж, боловсронгуй болгох санал боловсруулах	Санал-1	, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, холбогдох тайлан мэдээ, дүн шижилгээ	нийгмийн хамгааллын салбарын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, практикийг судалж, тэдгээрийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж, боловсронгуй болгох санал боловсруулсан байна.	системийн инженерчлэлийн аргаар тогтолцооны бүтцэд оруулах, уг тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай шийдлүүдийг хөгжүүлэх, нэвтрүүлэх замаар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар заалтаар баталгаажсан иргэдийн нийгмийн баталгааг хангах үндэсний тогтолцоог төгөлдөржүүлэх, загвар боловсруулах судалгааны багийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/54 тоот тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нийт 22 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, салбарт хэрэглэгддэг гол ойголт, нэр томьёоны тулгуур ойлголтыг “Тус солюшн” ХХК-аас гаргасан аргачлал, загварын дагуу тодорхойлж, Монгол Улсын Үндсэн хууль, Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Олон улсын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын тогтолцоонд бүрдүүлэх ёстой хэв шинжүүдээр задлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Судалгааны багийн ажлын нэгдсэн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 13-нд эцэслэн гарахаар төлөвлөгдсөн болно.		
--	---	---------	---	---	---	--	--

Зорилт 4. “ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЭН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХОЛБОГДОХ СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙГ СУДЛАН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”

1.	Хөдөлмөр эрхлэлтийн талаар олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын	Арга хэмжээний санал-1	2023 оны жилийн эцсийн тайлан	Салбарын бүртгэл, статистикийн мэдээ, тайлангийн маягтуудыг нэгдсэн стандарт	Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны Маягт, нөхөх зааврыг зөвшөөрөх тухай А/82 дугаар тушаалаар хөдөлмөрийн зах зээлийн ажил хайгч иргэний, бүртгэлтэй ажилгүй иргэний болон ажлын байрны захиалгын бүртгэлийн сарын мэдээний албан ёсны маягтыг Статистикийн тухай хуулийн 18 дугаар	2024.01.02-2024.12.31	100%
----	---	------------------------	-------------------------------	--	--	-----------------------	------

	байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, харьцуулалт, дүгнэлт танилцуулга хийж, мэдээллээр хангах, хууль тогтоомжийг шинэчлэх үндэслэл, хэрэгцээг тодорхойлж санал боловсруулах			загвараар боловсронгуй болгох санал өгч, батлуулсан байна.	зүйлийн 3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн салбарын яамны захиргааны статистикийн мэдээ болгон нийтэд түгээх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэн хүчингүй болгож, захиргааны мэдээ болгон шинэчлэн баталсан. Энэ хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зорилгоор ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тоот тушаалаар байгуулсан Хөдөлмөрийн салбарын бодлогын шинжилгээний ажлын хэсэг ажилласан. Тус ажлын хэсгээс хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, цаг хугацаа хэмнэх, хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын хэрэглээг хялбаршуулах, бүртгэл, тайлангийн маягтыг боловсронгуй болгох санал зөвлөмж гарсан. Энэ хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн маягтыг шинэчлэн, хялбаршуулахаар Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газар, хөдөлмөрийн хувийн биржийн холбоод болон холбогдох газар хэлтсийн мэргэжилтнүүдийн төлөөллийг хамруулсан ажлын хэсгийн 10 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан. Уулзалт, хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлт зөвлөмжид үндэслэн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн маягтыг хялбаршуулсан		
--	--	--	--	--	---	--	--

					бүртгэлийн маягт болгон шинэчлэн боловсруулсан. Дээрх хялбаршуулсан бүртгэлийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформд нэмэлтээр хөгжүүлэлт хийх, ажлын даалгаварт тусгаж оруулах, хэрэглээндээ нэвтрүүлж хэвшихийг ХХҮЕГ-т чиглэл болгон хүргүүлсэн.		
2.	Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх (Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр- 2.5.6, 2.5.15)	Хөдөлмөр эрхлэлтийн цахим сан-1	Онлайн портал, job matching буюу ажилд зуучлах үйлчилгээг нэвтрүүлсэн.	“Ejob” платформын Онлайн портал, job matching буюу ажилд зуучлах үйлчилгээ, мобайл аппликейшн, ухаалаг тайлан мэдээ гарах дашбоардыг нэвтрүүлсэн байна.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтын хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэн бүрт төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлсэн. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликейшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ. Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.	2024.01.02- 2024.12.31	100%

					Тус платформоос ухаалаг тайлан гарч байхаар хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүнд: - Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/82 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн захиргааны статистикийн сарын тайлан мэдээ, - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тайлан, - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны тайлан мэдээ, - Хөдөлмөрийн хувийн биржийн тайлан мэдээ болон бусад тайлан мэдээ, - Хөдөлмөрийн байгууллагын мэргэжилтнүүд болон удирдлагуудад зориулсан нийт 7 дашбоардыг хөгжүүлж дуусгасан. Түүнчлэн “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр “Ejob” платформын чанарын баталгааны 18 сарын хугацаанд техникийн туслалцаа үзүүлэх мэдээллийн технологийн ахлах зөвлөхийг 2023 оны 6 дугаар сараас 2024 оны 9 дүгээр сарыг дуусталх хугацаанд сонгон шалгаруулж, авч ажиллуулсан. Мэдээллийн технологийн ахлах зөвлөх нь ажлын даалгаварт туссан ажил үйлчилгээ аливаа алдаа, дутагдал, доголдол илэрвэл нэн даруй залруулах болон засвар шинэчлэлийг хийхэд тухай бүр мэргэжлийн туслалцаа үзүүлж хамтран ажилласан. Мөн Чанарын баталгааны 18 сарын хугацаа “Ejob” платформыг гүйцэтгэгч байгууллагаас бүрэн хүлээж авах үйл	
--	--	--	--	--	--	--

				ажиллагааны хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ажил эрчимжүүлж, яаралтай арга хэмжээ авч ажиллах үүрэг даалгавар хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ хүрээнд: ✚ Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем /ejob/ платформыг олон нийтэд таниулан сурталчлах төлөвлөгөө боловсруулан эхний байдлаар хэрэглэгчдэд зориулсан гарын авлагыг портал, гар утасны апплейкшн гэсэн 2 төрлөөр хэвлэн гаргасан. ✚ Хөдөлмөр эрхлэлтийн 2024 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний төсвийн хуваарийг арга хэмжээний төрөл тус бүрээр нь мөн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгодог жижиг зээлийн төсвийн хуваарь болон хамрах хүрээг төрөл тус бүрээр нь 21 аймаг 9 дүүргээр тохируулан системд оруулсан. ✚ Хөдөлмөр эрхлэлтийн цахим системийн АМЧБО, төсөл хөтөлбөр дээр гарсан өөрчлөлтийг Itzone ххк-иар засуулж 3 удаагийн уулзалт зохион байгуулав. ✚ Монголын хөдөлмөрийн хувийн биржүүдийн мэдээллийг сайжруулах сэдэвт сургалтанд ejob платформын танилцуулга, ажил зуулчлал, тайлангийн модулиудын талаар танилцуулга мэдээлэл хийсэн. ✚ Ажил зуучлалын тайлангийн модулийн алдааг засаж тоон мэдээллийн зөрүүг засаж засварлуулсан.	
--	--	--	--	--	--

					🌐 Портал дээр Гадаадаас ажиллах хүч авч буй байгууллагын мэдээллийг харуулдаг болгосон. 🌐 Ejob платформын серверийн хийлгүүлсэн. Цаашид ХХҮЕГ-ын холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй хамтран Ejob платформд хийж хөгжүүлэх шаардлагатай байгаа ажлын жагсаалтыг бэлтгэн, мэдээллийг ГБХНХЯ-ны ТНБД-д танилцуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийг туршилтаар байгуулж ажиллуулах тухай мэдээлэл бэлтгэх			Мэдээлэл бэлтгэсэн байна	8 хуудас бүхий Танилцуулга бэлтгэсэн.	2024.08.19	100%
2.	Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн саналд “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний стандартыг шинээр боловсруулж батлуулах” индикаторын мэдээллийг бэлтгэн хүргүүлэх			Мэдээлэл бэлтгэсэн байна	Индикаторын төслийн мэдээллийг бэлтгэн холбогдох мэргэжилтэнд албаны майл хаягаар хүргүүлсэн.	2024.08.20- 2024.09.20	100%
3.	Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэх арга туршлагыг цахим систем болон цахим үйлчилгээнүүдээр дэмжих, хэрэгцээ шаардлагад үндэслэн			Ажлын хэсэг байгуулсан байна	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эрхлэх асуудлын хүрээнд бусад чиглэлийн яам, холбогдох байгууллагуудтай хамтран албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэхэд цахим систем болон цахим	2024.06.13- 2024.11.21	100%

	цахимаар албажуулах саналыг боловсруулах Ажлын хэсэг байгуулах.				үйлчилгээнүүдийг дэмжих, хэрэгцээ шаардлагад үндэслэн цахимаар албажуулах санал боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг 2023 оны А/150 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлаар албан бус эдийн засгийг бүртгэлжүүлэх, албажуулахад ашиглах системийн загвар /дизайн/ боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Үүний дагуу бодлогын зөвлөмж боловсруулахаар мэдээллийн технологийн болон ахлах зөвлөх сонгон шалгаруулан ажиллуулж байна. Мэдээллийн технологийн болон ахлах зөвлөхүүд 2024 оны 5 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан, судалж албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэхэд тохирох цахим системийг сонгох бодлогын зөвлөмж боловсруулахаар ажиллалаа. Мөн 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр “Албан бус бизнесийн нэгж, ажиллагчдыг албажуулах чиглэлээр төрийн мэдээллийн системүүдэд үнэлгээ хийх, системийн загвар, функциональ шаардлагуудыг боловсруулах үндэсний зөвлөхийн тайланг хэлэлцүүлэх, санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллалаа. Төслийн зөвлөхүүд хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг тусган эцсийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр англи, монгол хэлээр хүлээлгэн өгсөн болно.	
--	---	--	--	--	---	--


4.	ХЭДТХ-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах			Ажлын хэсэгт орж ажилласан байна.	ХЭДТХ-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр орж ажиллаж байна. Тус ажлын хэсэг нийт 3 удаагийн вакумжсан хурал, уулзалт хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүд болон ТББ-ын төлөөллүүд оролцон Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний 181, 88 дугаар конвенцийн талаарх мэдээллийг хийсэн болно.	2024.11.05	100%
5.	ГБХНХ-ын салбарын үндсэн үзүүлэлтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2020-2023 оны байдлаар бэлтгэх			Мэдээлэл хүргүүлсэн байна	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үндсэн үзүүлэлтэд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийг 2020-2023 оны байдлаар бэлтгэн боловсруулав.	2024.11.28	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалтад хамрагдах.	Гадаад болон дотоодын сургалтад хамрагдсан сургалтын тоо		1-ээс дээш сургалт, семинарт хамрагдах.	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Хөгжиж буй орнуудын хүн ам ба тогтвортой хөгжил” сэдэвт семинарт хамрагдсан.	2024.11.01-2024.11.14	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого
төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
(Албан тушаал)

Н.Золжаргал /  /
(Нэр, гарын үсэг)

2024. 12. 05
.....
(Огноо)